

**Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар**

Байгууллагын нийт албан хаагчдыг бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох намрын сорилд хамруулах ажлыг Биеийн тамир спортын газартай хамтран зохион байгуулж нийт албан хаагчдыг хамрууллаа.

Салбарын тэргүүн болон ХХААЯамны хүндэт “Жуух бичиг”-ээр шагнуулсан иргэдийн шагналуудыг холбогдох газруудад хүргүүлсэн болно.

Байгууллагын ил тод байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу байгууллагын цахим хуудсанд аудитын тайлан, санхүүгийн тайлангуудын нэмж байрлуулж, ажилтнуудаас Сэтгэл ханамжийн судалгааг авах ажлууд зохион байгууллаа.

Төрийн байгууллагуудаас хуваарийн дагуу Мэргэжлийн хяналтын газраас Хөдөлмөрийн харилцааны эрх зүй сэдвээр сургалтыг авлаа.

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт, аргачлалын дагуу бэлтгэл ажлуудыг зохион байгуулж байна.

**Хоёр:Салбарын хүрээнд**

**Мал аж ахуй салбар:**

2015-2016 оны хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг 25 заалттайгаар боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Төлөвлөсөн ажлуудаас бүрэн хэрэгжсэн 11 заалт, хэрэгжих шатандаа 12 заалт, хугацаа болоогүй 2 заалт байна. Аймгийн мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангалтыг 9 үзүүлэлтээр дүгнэхэд 90,1 хувьтай байна.

Монгол улсын Засгийн газрын 292 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд 22,5 сая төгрөгөөр аюулгүйн нөөц өвс бүрдүүлэн Онцгой байдлын харьяа Дархан нөөцийн газрын саравчинд татан байршуулж дуусаад байна.

Сум болгон МУЗГ-ын 292 тоот тогтоолын дагуу өвсний нөөц бүрдүүлээд байна. Үүнд: Дархан сум өвс 40 тн, тэжээл 12 тн, Хонгор сум 100 тн өвс, Орхон сум 30 тн өвс, Шарын гол сум 40 тн өвс, 10 тн малын тэжээл тус тус бэлтгэсэн байна.

Бэлчээрийн даац хүрэлцээгүйгээс /өөр аймгийн нутагт/ Сэлэнгэ аймгийн хил залгаа Сайхан, Номгон, Баянгол, Мандал, Зүүнбүрэн, Жавхлант, Ерөө, Алтанбулаг

сумдын нутагт 348 өрхийн 14372 толгой бод, 63304 толгой бог бүгд 77676 толгой мал өвөлжихөөр сум хоорондын гэрээ хийгдээд байна.

ХХААЯ-наас ирсэн удирдамжийн дагуу Аймгийн Засаг даргын 2015 оны А/335 тоот захирамжаар Улсын төсвийн болон хөтөлбөр, төслийн хүрээнд бэлчээрийн зориулалттай шинээр гаргасан, сэргээн засварласан худгуудын бүртгэл, тооллогыг хийж байна. Аймгийн Аудитын газар, Орон нутгын өмчийн алба, Хөгжлийн бодлогын хэлтэс, ХХААГазрууд болон сумдын ЗДТГазар хамтран ажилласан болно. Уг шалгалтаар орон нутагт байгаа худгуудыг тоолон эзэнжүүлж, ажиллахгүй байгаа болон эвдэрсэн худгуудыг орон нутгийн өмчөөс хасаж актлах баримтжуулах ажлуудыг хийлээ. Тайлан мэдээг 12 дугаар сарын 1-нд нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлэх болно.

Отор нүүдэл хийж буй малчид болон малчдын бүлгүүдтэй холбогдох утасны судалгааг 4 сумаас авч жагсаалт гаргаад байна.

### **Мал эмнэлгийн салбар**

Мал эмнэлгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд өссөн дүнгээр 401,8 мянган толгой, паразит өвчнөөс сэргийлэх туулгалт, угаалга, боловсруулалтанд өссөн дүнгээр 720,5 мянган толгой малыг хамруулсан байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд байгалын голомттой боом, цусан халдварт, дуут хавдар, мялзан зэрэг халдварт өвчин гараагүй байна. Шүлхий өвчнөөс эрүүлийг баталгаажуулах тандалт шинжилгээнд 60 өрхийн 1200 толгой малыг санамсаргүй түүвэрийн аргаар хамруулж ийлдэс судлалын шинжилгээ хийхэд өвчтэй ийлдэс илэрээгүй байна.

Орон нутгийн нэгжүүдийн хаврын тарилгын үйлчилгээний хөлсний санхүүжилт болох 33,8 сая төгрөгийг холбогдох нэгжүүдэд шилжүүлэв. Намрын тарилгын баримт материалыг нэгжүүдээс авч хянан үзэж байна. Монгол мал үндэсний хөтөлбөрийн хүрээнд энэ жилийн охин хурга, ишиг, тугалд бруцеллёзын тарилга хийсэн үндсэн баримтыг бүрдүүлэн МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг үржлийн газарт хүргүүлэн санхүүжилийн хөрөнгийг шийдвэрлүүлэхээр уламжлаад байна.

Мал эмнэлгийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл бэлтгэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлүүлэхээр уламжлаад байна.

### **Газар тариалангийн салбар**

Буудайн хувиарлалтыг аж ахуйн нэгж иргэнээр гарган ХХААЯ, ХБХэлтэст албан тоотоор хүргүүллээ. Нийт аймгийн хэмжээнд буудай 6178.5 га-аас 3812.5 тн буюу га-аас 6.2 цн/га, тосны ургамал 2138.2 га-аас 609.6 тн, төмс 307.8 га-аас 2931.9 тн, хүнсний ногоо 757.3 га-аас 4695.8 тн, малын тэжээл 1937.8 га-аас 1937.8 тн ургац хураан авсан дүнтэй байна. Хураан авсан ургац нь аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт үр тариагаар 40.4 хувь, төмсөөр 59.6 хувь, хүнсний ногоогоор 64.7 хувиар хангах боломжийг бүрдүүллээ.

Нийт 3812 тонн буудай хураан авсанаас өөрийн үрэнд 511тонн, улсын үрийн нөөцөд 172.5 тн, ТЭДсанд 362,5 тн, гурлын үйлдвэрүүдэд 2345,5 тн, борлуулагдаагүй үлдсэн 203.7 тонн байна.

Өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад буудай 11.4 мянган тонноор, төмс 4.1 мянган тонноор, хүнсний ногоо 10.8 мянган тонноор, тосны ургамал 3.5 мянган тонноор буурч, малын тэжээл 956 тонноор өссөн дүнтэй байна.

Чацаргана үйлдвэрлэлтийн мэдээгээр хөтөлбөрийн хүрээнд 26 иргэн, аж ахуйн нэгж, хоршоонд 143.8 сая төгрөгийн нийт 35125 ширхэг суулгацыг олгож аймгийн хэмжээнд 126.3 га-д жимс жимсгэний үйлдвэрлэлийг явуулж байгаа мэдээтэй байна.

Уринш боловсруулалтыг 12500 га-д хийхээр төлөвлөснөөс 48 аж ахуйн нэгж 66 иргэн 12277.3 га-д чанар сайтай уринш хийсэн мэдээтэй байна.

### **Хүнсний үйлдвэрлэлийн салбар**

ХХААЯам, Аймгийн тогоочдын холбоотой хамтран хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажилтан, ажиллагсдад Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг сурталчилах зорилгоор “Хоол үйл, үйлчилгээний салбарт эрүүл ахуй, зохистой дадал нэвтрүүлэх нь” сургалтыг 11 сарын 20-нд зохион байгуулж 120 тогооч оролцлоо. Мөн 11 сарын 21-нд “Аймгийн аварга тогооч” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Дэлхийн зөн ОУБайгууллага, ХХААЯ-тай хамтарсан “Газар хөдлөлтийн гамшгийн үеийн орон нутгийн хүн амын хүнсний нөөц тооцох аргачлал” сэдэвт сургалтанд хүнсний мэргэжилтэн хамрагдсан байна.

Тайланг нэгтгэсэн: Архив, Бичиг хэргийн эрхлэгч ..... Д.Ганбаяр

Тайланг хянасан: ЗУХэлтсийн дарга ..... Б.Бат-Эрдэнэ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
2015 ОНЫ 12 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийгдэх ажил	Огноо	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
<b>Захиргаа удирдлагын хэлтэс</b>				
1	ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг ХБХэлтэст хүргүүлэх.	Сардаа	Б.Бат-Эрдэнэ	Тайланг хугацаанд нь хүргүүлэх.
2	Жилийн эцсийн тайлангуудад ХШҮ хийх ажлыг зохион байгуулах.	сардаа	ХШҮ-ний баг	ХШҮ-ний тайлангууд гарсан байна.
	Дотоод аудитын төлөвлөгөөний ажлуудыг зохион байгуулах.	сардаа	Б.Бат-Эрдэнэ	Төсвийн ил тод байдал сайжирна.
3	Байгууллагын ил тод байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу ажлууд зохион байгуулах.	сардаа	ЗУХэлтэс	Байгууллагын ил тод байдал сайжирсан байна.
4	Төрийн байгууллагуудаас хуваарийн дагуу сургалтуудыг авах.	сардаа	Б.Бат-Эрдэнэ	Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг нэмэгдэнэ.
<b>Мал аж ахуйн хэлтэс</b>				
5	2015 оны тэжээвэр амьтан, мал тооллогын ажлын бэлтгэл хангана. Сургалт семиннарт оролцох	Сардаа	МААХ	Б.Оюунтөгс
6	Бэлчээрийн худгийн үзлэг тооллогыг дуусгаж тайлан мэдээг нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлэх			Тайланг үнэн зөв гаргасан байна.
7	Оны эцсийн тайлан мэдээ гаргаж ХХААГ-ын нэгтгэлд өгөх			Мэдээ, мэдээлэл үнэн зөв бодитой гарсан байна.
<b>Мал эмнэлгийн хэлтэс</b>				
8	Орон нутгийн нэгжүүдийн намрын тарилгын материалыг бүрдүүлэн хянаж үзэх	12-р сарын 10-ны дотор	Мал эмнэлгийн хэлтэс	Тайланг хугацаандаа хүргүүлэх
9	Урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсний үлдэгдэл	Сардаа		Тайланг хугацаандаа хүргүүлэх

	санхүүжилтийг олгуулах			
10	Мал эмнэлгийн арга хэмжэний жилийн эцсийн мэдээ тайлан гаргах	Сардаа		Санхүүжилтийг олгосон байна.
11	Бруцеллёзын тарилга хийсэн үйлчилгээний хөлсний санхүүжилтийг олгох	Сардаа		Үндсэн баримт материалыг хянан үзсэн байна.
12	Үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг гаргах	Сардаа		Санхүүжилтийг шилжүүлэн авсан байна.
13	Орон нутгийн нэгжүүдтэй байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэх	Сардаа		Хугацаандаа гаргасан байна.
<b>Хүнс, газар тариалангийн хэлтэс</b>				
14	Газар тариалангийн үйлдвэрлэлтийн суурь судалгаанд баяжилт хийх	Сардаа		
15	Чацаргана хөтөлбөрийн хүрээнд 2015 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, хамгаалагдсан үйлдвэрлэлийн тайланг гаргаж ХХААЯ-нд хүргүүлэх	Сардаа	ХГТХэлтэс	

**Хүнс, хөдөө аж ахуйн газар**